

МОНГОЛ ОРНЫ БЭЛЧЭЭРИЙН СЭРГЭХ ЧАДАВХИЙН ЗАРЧИМ

Монгол орны бэлчээрийн төлөв байдлыг үндэсний түвшинд үнэлэх зорилгоор “бэлчээрийн сэргэх чадавхийн зарчим”-ыг боловсруулсан болно. “Бэлчээрийн сэргэх чадавхийн зарчим”-ыг боловсруулахдаа бэлчээрийн лавлагаа төлөв байдал буюу экологийн чадавхи (ургамлын тухайн бүлгэмдлийн соргог төлөв байдал) болон ашиглалтыг өөрчлөх замаар сэргээн сайжруулах талаарх мэдлэг мэдээлэлд тулгуурласан төсөөлөлийг үндэс болгов. “Бэлчээрийн сэргэх чадавхийн зарчим” нь уг чанартаа Монголд аль хэдийнээс хэрэглэж ирсэн талхлагдлын зэрэг хэмээх ойлголттой утга нэг зүйл бөгөөд гол нь тоон үзүүлэлтэд тулгуурлан тогтоосон сэргэх чадавхи болон бэлчээрийн экологийн чадавхийн мэдээлэл дээр суурилснаараа онцлогтой. Энэхүү “бэлчээрийн сэргэх чадавхийн зарчим”-ыг ашиглахад ургамлын бүрхэц, өнгөн хөрсний төрх байдал зэрэг бэлчээрийн экологийн чадавхийн мэдээлэлтэй дүйлгэн харьцуулсан мэдээлэл шаардлагатай болдог. Бэлчээрийн сэргэх чадавхийн зарчмаар Монгол орны бэлчээрийг дараахь байдлаар ангилах боломжтой:

Анги I. Ургамлын бүлгэмдэл лавлагаа төлөв байдал (талхлагдаагүй)-тай бараг ойролцоо, эсвэл бага зэрэг талхлагдсан төлөв байдлаас лавлагаа төлөв байдалд шилжихэд ургалтын ургалтын 1-3 улирал шаардагдах, ашиглалтын эрчим (ачаалал) тэжээлийн нөөц (даац)-тэй үндсэндээ дүйж байгаа (4.4-г үзэх), түүнчлэн улирлаар сэлгэж ашиглах шаардлагатай

Анги II. Ургамлын бүлгэмдэл сөрөг тал руу бага зэрэг өөрчлөгдсөн, хур тунадас боломжийн байх, эсвэл ашиглалтын хэлбэр (ачааллыг бууруулах, улирлаар сэлгэх, түр амраах)-ийг зохистой өөрчилж чадсан тохиолдолд богино хугацаа (ургалтын 3-5 улиралд)-д сэргэх боломжтой. Өөрчлөлт нь урт хугацаанд бэлчээрийн тэжээлийн хангамж, экосистемийн бусад үйлчилгээнд ноцтой нөлөөлөх хэмжээнд хүрээгүй, тийн үнэлэх үндэслэлгүй

Анги III. Ургамлын бүлгэмдэл нэлээд өөрчлөгдсөн, хур тунадас боломжийн байх, эсвэл ашиглалтын арга хэлбэр (ачааллыг бууруулах, улирлаар сэлгэх, түр амраах)-ийг шаардлагатай хэмжээнд өөрчилж чадсан тохиолдолд ургамал ургалтын 5-10 улиралд сэргэх боломжтой. Өөрчлөлтийн улмаас экосистемийн зарим чухал үйлчилгээ алдагдсан (хүний үйл зохисгүй ажиллагаанаас үүдэлтэй болох нь тодорхой), гэхдээ цаг хугацааны тодорхой эргэлтэд сэргэх боломж бий.

Анги IV. Зонхилох зүйл ургамал устаж, хортой болон ашиггүй зүйл ургамал хүчтэй түрж түүнчлэн усзүйн горим өөрчлөгдсөний улмаас эргэж нөхөн сэргэнэ гэх найдвар тун бага, харин үр хачирлах, түрэгч ургамлыг устгах, усны горимыг дахин сэргээх замаар хэдэн 10 жил эрчимтэй ажиллагаа явуулбал сэргэж болзошгүй (экологийн чадавхийн босгоос давж доройтсон). Экосистемийн үндсэн үйлчилгээ бүрмөсөн алдагдсан, эргэж сэргээхэд маш их хөрөнгө зардал шаардана.

Анги V. Өнгөн хөрсний алдагдал, эрчимтэй элэгдэл, давсжилтийн улмаас ургамал бүлгэмдэл хүчтэй өөрчлөгдөж, гол түлхүүр зүйл ургамлууд устаж алдагдсан. Ургамал-хөрсний харилцан хамаарал, үйлчлэл болон хөрсний шинж чанар үлэмж хэмжээгээр доройтож өөрчлөгдсөн нь доройтлын төлөв байдал арилахгүй хадгалагдах гол нөхцөл болж байгаа. Экосистемийн үндсэн үйлчилгээ бүрмөсөн алдагдсан, нөхөн сэргээх боломж үндсээрээ байхгүй (жинхэнэ цөлжилтэд өртсөн гэж үзэх талтай).

RECOVERY CLASS CONCEPT FOR MONGOLIAN RANGELANDS

In order to create a national assessment of rangeland health that incorporates variations in ecological potential across Mongolia, standardized “recovery classes” were developed.

Recovery classes are based on information and assumptions about the reference condition or ecological potential of a pasture area (the plant communities expected to exist at a site in healthy condition) and the process of recovery with a change in management. The recovery classes are analogous to degradation classes already used in Mongolia, but are based on ESDs and provide information about recovery rates based on quantitative measurements. Assigning a recovery class to a site requires measurements of plant cover and soil surface conditions that are compared with the information in the appropriate ESD.

According to the Recovery class concept, Mongolian rangelands could be classified by following classes:

Class I. The plant community is at or near reference conditions (non-degraded) or requires 1-3 growing seasons for recovery from minor changes (slightly degraded); match stocking rate to forage supply (see 5.2 below) and use temporary seasonal deferment as needed.

Class II. The plant community is altered and may be rapidly recovered (3-5 growing seasons) with favorable climatic conditions or a change in management (e.g., stocking rate reduction, seasonal deferment, rotation). The nature of alteration is not regarded as a significant long-term threat to the provision of forage and other ecosystem services.

Class III. The plant community is altered and may take 5-10 growing seasons to recover with changed management (stocking rate reduction, seasonal deferment, and long-term rest). Alteration represents a significant loss of important ecosystem services (and are clearly related to anthropogenic drivers), but recovery is possible in time.

Class IV. The plant community is altered due to the local loss of key plant species, invasion of noxious plant species, or alteration of hydrology that is unlikely to be recovered for over a decade to many decades without intensive interventions such as species removal, seeding, or manipulations to recover historical hydrological function (i.e. an ecological threshold was crossed). Previous ecosystem services have been lost and are usually costly to recover.

Class V. The plant community is altered due to extensive soil loss, accelerated erosion rates, or salinization. Altered plant-soil feedbacks or permanent changes in the soil profile maintain the degraded state. Previous ecosystem services have been lost and it is usually impractical to recover them (often regarded as true desertification).